

МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ХУРААНГУЙ ТЭМДЭГЛЭЛ

№ 24/3

Улаанбаатар хот

Мөнгөний бодлогын хороо (МБХ) 2024 оны 6 дугаар сарын 25, 7 дугаар сарын 2-ны өдрүүдэд хуралдаж, хуралдааныг Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн удирдав. Хуралдааны эхний өдөр мөнгөний бодлогын хэрэгжилт, эдийн засаг, банкны салбарын өнөөгийн байдлын талаар Монголбанкны хариуцсан газрууд танилцуулж, хэлэлцүүлэг өрнүүлэв. Хуралдааны хоёр дахь өдөр эдийн засгийн цаашдын төлөв, мөнгөний болон макро зохистой бодлогын саналын талаар хэлэлцэж, бодлогын шийдвэрийг гаргалаа.

Хуралдааны эхний хэсэгт мөнгөний бодлогын хэрэгжилтийн талаар танилцуулав. Голомт банк олон улсын зах зээл дээр бонд гаргасан нь гадаад валютын орох урсгалыг дэмжиж, цэвэр урсгал өмнөх оны мөн үеэс 764 сая ам.доллаарой сайжрав. Түүнчлэн, нүүрсний экспорт эхний 6 сард нэмэгдэж, валютын орох урсгалыг дэмжиж байгаа ч хилийн үнэ буурснаар экспортын орлого саарах нөлөөтэй байгааг дурдлаа. Засгийн газрын зээлийн төлбөр, Хуралдай бонд, Хятадын ардын банктэй хийсэн своп хэлцлийн 4.5 тэрбум юанийн эргэн төлөлтүүдтэй холбоотойгоор ГВАН-ийн хэмжээ оны эхнээс 318 сая ам.доллаарой буурсан байна. ТБҮЦ-ны үлдэгдэл оны эхнээс 9.9 их наяд төгрөгөөр буюу 12 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үргэлжлүүлэн ипотекийн зээлийн хөтөлбөрийн хэрэгжилт, банк хоорондын захын арилжаа, валютын ханшийн өөрчлөлтийн талаар танилцуулав.

Хурлын дараагийн хэсэгт банкны системийн өнөөгийн байдлын талаар танилцуулав. Банкны салбарын нийт актив энэ оны 5 дугаар сард өмнөх оны мөн үеэс 10.7 их наяд төгрөгөөр буюу 23 хувиар өсөж 57.3 их наяд төгрөгт хүрчээ. Банкны салбарын зээл өмнөх оны мөн үеэс 37 хувиар өссөн ба үүний дийлэнх хэсгийг иргэдийн зээл, тэр дундаа ипотек, цалин, өрхийн үйлдвэрлэлийн зээл бүрдүүлж байна. Цаашлаад малчны зээлтэй холбоотой авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар танилцуулав. Тодруулбал, зудын нөхцөл байдалтай холбоотойгоор эргэн төлөлт нь доголдсон зээлийн хугацааг 1 жилээр сунгасны улмаас нийт олгогдсон зээлийн үлдэгдлийн 80 орчим хувийг зээлийн батлан даалтын сангаас эрсдэлийг даасан. Энэ нь чанаргүй зээлийг нэмэгдүүлж, төсөвт дарамт учруулж болзошгүйг дурдлаа. Танилцуулгын төгсгөлд банкны системийн нөлөө бүхий банкуудын зохистой харьцааны биелэлт, шалгуур үзүүлэлт, зээлийн чанарын талаар танилцуулав.

Цаашлаад МБГ-аас мөнгөний бодлогын саналыг эдийн засгийн суурь төсөөлөл, түүнд ашигласан таамаглалт нөхцөлүүд, хувилбар төсөөллүүдэд үндэслэн танилцуулав. Инфляц энэ оны 5 дугаар сард улсын хэмжээнд 5.7 хувьд хүрч буурлаа. Үүнд, импортын бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт бага байсан, суурь үеийн нөлөөгөөр дотоодын хүнсний инфляц саарсан зэрэг нь инфляц буурахад голлон нөлөөлж байна. Түүнчлэн, инфляцыг бууруулж, эдийн засгийг тогтворжуулах зорилгоор авч хэрэгжүүлсэн мөнгөний хатуу бодлого үр дүнд

хүрч, инфляц сүүлийн 6 сарын хугацаанд зорилтын голчийн орчимд ирж тогтворжсоныг дурдлаа. Инфляцад үзүүлэх эрэлт, нийлүүлэлтийн хүчин зүйлсийн нөлөө хүлээлтээс бага байгааг харгалзан энэ оны төсөөллийг бууруулав. Харин ирэх оноос гадаад үнүүд эргээд өсөх, дотоод эрэлт идэвхжих, дэлхийн зах зээл дээрх хүнсний үнэ өсөх зэрэг нөлөөгөөр инфляц алгуур нэмэгдэж, зорилтын дээд интервалын орчимд хэлбэлзэхээр байгааг танилцуулав. Улмаар 2026 оны сүүлээс инфляц зорилтын голч руу дөхөх хүлээлттэй байна.

Эдийн засгийн өсөлт хүлээлтээс давж, энэ оны 1 дүгээр улиралд 7.8 хувиар өслөө. Уул уурхай, тээврийн салбарын өсөлтийн эрч хадгалагдаж, аж үйлдвэр, үйлчилгээний салбар эхний улиралд эдийн засгийн өсөлтийн 6.0 нэгж хувийг бүрдүүлсэн байна. Энэ оны эдийн засгийн өсөлтийн төсөөллийг өмнөхөөс нэмэгдүүлж авч үзсэн бөгөөд үүнд; нүүрсний экспортын төсөөлөл сайжирсан, орон сууцны санхүүжилт нэмэгдэхээр батлагдсан, өрхийн хэрэглээ тэлж, дотоод эрэлт сайжрах зэрэг нь уул уурхай, тээвэр, барилга, бүтээгдэхүүний цэвэр татварын орлогыг дэмжинэ гэж үзлээ. Харин зудын нөхцөл байдал тооцоолсноос хүндэрч, хөдөө аж ахуйн салбарын өсөлт өмнөх төсөөллөөс буурах, улмаар боловсруулах салбарын үйлдвэрлэл өмнөхөөс саарахаар хүлээгдэж байна. Ирэх онд цаг агаарын хүндрэл арилж, Оюу толгойн үйлдвэрлэл эрчимжин эдийн засгийн өсөлт 6-7 хувийн орчимд хүрэхээр байгааг танилцуулав.

Төсвийн нийт тэнцэл энэ оны 4 дүгээр сард 2.1 их наяд төгрөгийн ашигтай гарлаа. Сүүлийн 2 жилийн хугацаанд төсвийн орлого бүрдүүлэлт сайн байж, хүлээлтээс давсан гүйцэтгэлтэй байв. Үүнд, бүтээгдэхүүний цэвэр татвар, нэмүү өртгийн албан татвар гол эерэг нөлөөг үзүүлжээ. Ирэх онуудад төсвийн төлөв Сангийн яамны тооцооноос давж биелж байгаа тул шаардлагатай санхүүжилтийн хэмжээ бага байх төлөвтэй байна.

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт энэ оны 4 дүгээр сард 26.3 хувьд хүрч нэмэгдэж, банкны системийн зээлийн өсөлт 26.4 хувьд хүрч үргэлжлэн эрчимжив. Бизнесийн зээл тайлант сард өмнөх оны мөн үеэс 2.4 их наяд төгрөгөөр буюу 17.8 хувиар өссөн ба энэхүү өсөлтийн 900 тэрбум нь хөнгөлөлттэй зээл, үүний 800 орчим тэрбум нь хүнсний хувьсгал болон хөдөө аж ахуйн салбарыг дэмжих зээлүүд эзэлж байгааг онцоллоо. Энэ онд төсвийн тэнцэл сайжирч, засгийн газрын цэвэр зээл өмнөх төсөөллөөс буурах нөлөөгөөр М2 мөнгөний өсөлтийн төсөөлөл өмнөхөөс саарах хүлээлттэй байна. Харин зээлийн өсөлтийн төсөөлөл өмнөхөөс нэмэгдэхээр байгаа бөгөөд үүнд; Хуримтлалын сангаас 500 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг ипотекийн зээлд зарцуулах, “Хоршоодын малчдын зээл”-ийн хүрээнд 500 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгох зэрэг нь нөлөөлж байгааг дурдлаа.

Үргэлжлүүлэн гадаад эдийн засгийн орчин, төлбөрийн тэнцлийн талаар танилцуулав. БНХАУ-д эдийн засгийн идэвхжил сул байж, дотоод эрэлт сэргэх хурд удааширснаар эдийн засгийн өсөлтийн төлөв муудлаа. Геополитикийн эрсдэл, тодорхой бус байдал өндөр байгаагаас шалтгаалж алтны үнийн төсөөлөл нэмэгдэж, цахилгаан автомашины үйлдвэрлэл эрчимжсэнээр зэсийн эрэлт болон үнэ өмнөх төсөөллөөс сайжирсан байна. Гадаад худалдааны гүйцэтгэлийг авч үзвэл нүүрсний биет хэмжээ өссөн дүнтэй байгаа ч хилийн

үнэ буурснаар экспортын орлого эхний улиралд өмнөх оны мөн үеэс 1 хувиар буурсан бол импорт өмнөх оны мөн үеэс 24.5 хувиар өссөн байна. Тодруулбал, уул уурхайн экспорттой уялдан хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, дизель түлшний импорт нэмэгдсэнээс гадна хэрэглээний импорт, тэр дундаа суудлын автомашин, удаан эдэлгээт барааны импортын өсөлт өндөр байгааг онцлов. Цаашлаад энэ онд нүүрсний экспортын төсөөлөл нэмэгдсэн, зэс, алт зэрэг эрдэс түүхий эдүүдийн үнийн төсөөлөл сайжирсан, банкуудын гадаад зээлийн ашиглалт нэмэгдэх зэрэг нөлөөгөөр төлбөрийн тэнцлийн төсөөлөл өмнөхөөс сайжирсныг танилцуулав. Эцэст нь инфляцад нөлөөлөх гадаад, дотоод орчны эрсдэл, цаашдын төлөвийг харгалзан бодлогын хүүг 11 хувьд хэвээр хадгалах саналыг гишүүдэд танилцууллаа.

Үргэлжлүүлээд хэрэглээний зээлийн нөхцөл байдал, санхүүгийн системд тулгарч болзошгүй эрсдэл, макро зохистой бодлогын хүрээнд авч хэрэгжүүлэх шаардлагатай зарим арга хэмжээний саналыг МБГ-аас танилцууллаа. Тодруулбал, өнгөрсөн 2 жилийн хугацаанд цалин, тэтгэврийн өсөлтийг даган хэрэглээний зээлийн өсөлт эрчимжиж, банк болон банк бус санхүүгийн байгууллагаас зээл авсан давхар зээлтэй иргэдийн тоо болон зээлийн дүн эрчимтэй нэмэгдсэн байна. Тухайлбал, энэ оны 3-р сарын байдлаар банк болон ББСБ-ын давхар зээлтэй иргэдийн тоо 350 мянгад хүрч, өмнөх оны 5 сартай харьцуулахад 26.4 хувиар нэмэгджээ. Түүнчлэн, давхар зээлтэй иргэдийн дундаж ӨОХ ойролцоогоор тооцвол 79.8 хувьтай байгаа нь зээлийн төлбөрийн бодит дарамт нэмэгдэж, өндөр болсныг илтгэж байна. Мөн банкууд хэрэглээний зээлийн хувьд чанарын ангилал хийхдээ зээлдэгчийн орлого, өр төлбөрийн өөрчлөлтийг төдийлөн харгалзахгүй байгаа нь зээлийн эрсдэлийг дутуу үнэлэх эрсдэлтэйг анхааруулав. Ингээд хэрэглээний зээлийн зохицуулалттай холбоотой макро зохистой бодлогын арга хэмжээний саналуудыг гишүүдэд танилцуулав. Үүнээс гадна, банкуудын эх үүсвэрийн долларжилт өмнөх оны эхнээс 10 гаруй хувиар буурсан энэ үед гадаад валютын ЗБН-ийн шаардлага өндөр байгаа нь банкуудын эх үүсвэрийн зардлыг өсгөж байгаа тул гадаад валютын татан төвлөрүүлсэн хөрөнгөнд тооцох ЗБН-ийн хувь хэмжээг 3 хувиар бууруулж 15 хувиар тогтоох саналыг МБГ-аас дэвшүүллээ.

Ийнхүү дээрх саналуудтай холбоотойгоор МБХ-ны гишүүд асуулт асууж, хэлэлцүүлэг өрнүүлэв. Инфляц төсөөлөлтэй нийцтэйгээр буурч байгаа боловч, ирэх оноос гадаад үнүүд өсөх, дотоод эрэлт идэвхжих нөлөөгөөр инфляцын дарамт нэмэгдэх эрсдэлтэйг харгалзан бодлогын хүүг 11 хувьд хэвээр хадгалах шийдвэрт гишүүд санал нэгдлээ. Түүнчлэн, гадаад валютын заавал байлгах нөөцийн хувийг бууруулан тогтоох нь дотоодын банкуудын өртөг, зардлыг бууруулан өрсөлдөх чадварыг дэмжих, валютын эх үүсвэр гадагшлахаас сэргийлэхэд эерэг нөлөөтэйг онцолж, гадаад валютын татан төвлөрүүлсэн хөрөнгөнд тооцох ЗБН-ийн хувь хэмжээг 15 хувьд хүргэхийг бүх гишүүд дэмжлээ.

Үргэлжлүүлээд хэрэглээний зээлтэй холбоотой саналуудыг хэлэлцэв. Хэрэглээний зээлийн өсөлт өндөр байгаагийн зэрэгцээ банк болон бусад санхүүгийн байгууллагын давхар зээлтэй иргэдийн тоо, зээлийн дүн огцом өссөн байгаа нь хэрэглээний зээл олголтыг хязгаарлах зайлшгүй шаардлагатайг гишүүд онцлов. Нэг гишүүний зүгээс банкны салбарт хэрэглээний зээлийг ийнхүү хязгаарлах нь иргэд бусад санхүүгийн байгууллагуудаас илүү өндөр хүүтэй

зээл авч, иргэдийн өрийн дарамт болон санхүүгийн системийн эрсдэл улам нэмэгдэх эрсдэлтэйг дурдлаа. Бусад гишүүдийн зүгээс нэгэнт бий болсон тус эрсдэлийг бууруулах зорилгоор хэрэглээний зээлийн зохицуулалтыг чангатгахаас өөр аргагүй болж байна гэсэн нэгдсэн байр суурийг илэрхийлэв. Ингэхдээ санхүүгийн зохицуулагч байгууллагуудтай энэ талаар харилцан санал солилцож, системийн хэмжээнд эрсдэлийг бууруулах чиглэлээр хамтран ажиллах нь илүү үр дүнтэй гэж үзэв. Ийнхүү банкнаас иргэдэд шинээр олгох болон нөхцөл өөрчилсөн хэрэглээний зээлийн хувьд өр, орлогын харьцаа (ӨОХ)-ны дээд хязгаарыг 55 хувь болгож бууруулах саналыг гишүүд 100 хувийн саналаар дэмжлээ.

Цаашлаад; 1) бага дүнтэй кредит картын зээлд ӨОХ тооцохгүй байх, 2) тодорхой нөхцөлүүдийг хангасан бакалаврын сургалтын төлбөрийн зээлийг ӨОХ-ны болон хугацааны хязгаарлалтаас чөлөөлөх, 3) банкууд зээлдэгчийн ӨОХ-г улирал бүр шинэчлэн тооцож, Монголбанкны тогтоосон хязгаараас давсан тохиолдолд тусгай эрсдэлийн сан нэмэлтээр байгуулах тухай хэлэлцүүлэг өрнөлөө. Эхний саналын тухайд иргэдэд бага дүнтэй хувийн санхүүгийн зайлшгүй хэрэгцээгээ хялбар санхүүжүүлэх боломжийг олгож, кредит картын хэрэглээг хэвшүүлэх ач холбогдолтойг онцолж, гишүүд саналыг дэмжлээ. Дараагийн саналын хувьд нэг гишүүний зүгээс зөвхөн бакалавр гэлтгүй магистр, докторын суралцагчдад зээл авах боломжийг олгож, саналыг ерөнхий байдлаар томьёолох нь зүйтэй гэсэн байр суурийг илэрхийлж, үүнийг бусад гишүүд 100 хувийн саналаар дэмжлээ. Түүнчлэн, гишүүдийн зүгээс банкуудын бүтээгдэхүүн бүрт ийнхүү ялгаатай зохицуулалт хийх шаардлага бий эсэх тал дээр харилцан санал солилцож, хэрэглээний зээлийн өсөлтийг хязгаарлах зайлшгүй шаардлага байгаа ч бүхэлд нь хязгаарлалгүй, кредит картын зээл, боловсролын зээл зэрэг нийгэмд эерэг үр нөлөөтэй, ач холбогдолтой зээлүүдийг дэмжих нь зүйтэй гэсэн нэгдсэн байр суурьт хүрлээ. Эцэст нь зээлдэгчийн ӨОХ-г тогтмол шинэчлэн тооцож, тусгай эрсдэлийн сан нэмэлтээр байгуулах талаар гишүүд хэлэлцэж, тус санал нь зарчмын хувьд зөв боловч хэрэгжүүлэх үйл явц нь нарийн төвөгтэй бөгөөд иргэд бусад санхүүгийн байгууллагаас зээл авахад банкууд эрсдэлийн сан нэмэлтээр байгуулах нь зохисгүй гэсэн үндэслэлээр тус саналыг хойшлуулж, Монгол Улсын Сангийн яам болон Санхүүгийн зохицуулах хороотой ярилцах чиглэл өгөв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 2024 оны 6 дугаар сарын 25, 7 дугаар сарын 2-ны өдрийн ээлжит хурлаар эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, гадаад орчны эрсдэлийг харгалзан үзээд:

1. Бодлогын хүүг 11 хувьд хэвээр хадгалах;
2. Банкуудын гадаад валютын заавал байлгах нөөц (ЗБН)-ийн хувь хэмжээг 3 нэгж хувиар бууруулж, 15 хувьд хүргэх;
3. Хэрэглээний зээлийн хувьд мөрдөгдөж буй макро зохистой бодлогын зохицуулалтад дараах өөрчлөлтийг оруулах. Үүнд:

- a. Банкнаас иргэдэд шинээр олгох болон нөхцөл өөрчилсөн хэрэглээний зээлийн хувьд өр, орлогын харьцаа (ӨОХ)-ны дээд хязгаарыг 55 хувь болгож бууруулах,
- b. Банкнаас шинээр олгох амьжиргааны баталгаажих доод түвшнээс бага дүнтэй кредит картын зээлд ӨОХ-ны хязгаарлалт мөрдүүлэхгүй байх,
- c. Тодорхой нөхцөлүүдийг хангасан дээд боловсролын сургалтын төлбөрийн зээлд ӨОХ-ны болон хугацааны хязгаарлалтыг мөрдүүлэхгүй байх шийдвэрийг тус тус гаргалаа.

Бодлогын саналын шийдвэр

